



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 24 өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.4, 6.6 дахь заалт, 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй нийт 111,418,376.91 (нэг зуун арван нэгэн сая дөрвөн зуун арван найман мянга гурван зуун далан зургаан төгрөг ерэн нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуриимтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 2 ширхэг автомашиныг акталж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг хууль тогтоомж, журмын дагуу Байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Акталж, данснаас хасаж сэлбэгээр худалдсан автомашины улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчөөс бүртгэлээс хассан тодорхойлолт, дээрх арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.Н.Дулан

Д.НАРАНГЭРЭЛ

132001539

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 06 дүгээр сарын 24-ны өдрийн
29 дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины нэр, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /ашиглалтад/ орсон он	Нэг бүрийн үнэ	Балансын үнэ, хуриимтлагдсан элэгдэл
			/төгрөг/	
1	Автомашин MMC 84-53 УБВ, хагас ачаа, арал: X34-1100927	1995/2002	12,979,010.00	12,979,010.00
2	Автомобиль ланд ровер 07-72 УБЗ, суудал, арал: SAILAA 379435	2006/2006	98,439,366.91	98,439,366.91
НИЙТ ҮНЭ			111,418,376.91	111,418,376.91
			(нэг зуун арван нэгэн сая дөрвөн зуун арван найман мянга гурван зуун далан зургаан төгрөг ерэн нэгэн мөнгө)	